



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2015 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/176

Хэрлэн сум

Хүүхэд үрчлүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Иргэний Улсын бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, Иргэний бүртгэл хөтлөх журмын 12 дугаар зүйл, Гэр бүлийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.6, 55.7, 55.8 дахь заалт, 57 дугаар зүйлийн 57.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэрлэн сумын иргэн Шар Гучид ургийн овогт Эрболдын Ивээлт (СЮ20252557), Шар Гучид ургийн овогт Эрболдын Болоржин (СЮ16242506) нарыг үрчлэн авах хүсэлт гаргасан Хэнтий аймгийн Хэрлэн сумын 5 дугаар багийн иргэн Бэсүд ургийн овогт Пунцагдашийн Ганцоож (СЙ82031337), Хар Гэндэн ургийн овогт Лувсанпүрэвийн Доржханд (СО95112005), үрчлүүлэх хүсэлт гаргасан Хэнтий аймгийн Хэрлэн сумын 5 дугаар багийн иргэн Шар Гучид ургийн Оюунчимэгийн Эрболд (СЮ95110918) нарын хүсэлтийг тус тус хянан үзээд Пунцагдашийн Ганцоож, Лувсанпүрэвийн Доржханд нарт үрчлүүлсүгэй.

2.Э.Ивээлт, Э.Болоржин нарыг өөрийн төрсөн хүүхдийн адил тэжээн тэтгэж, өсгөн хүмүүжүүлэхийг П.Ганцоож, Л.Доржханд нарт үүрэг болгосугай.

3.Дээрх заалтын дагуу холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн иргэний улсын бүртгэлийн нэгдсэн санд тусгуулахыг улсын бүртгэгч (Э.Өнөрбаяр)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭРДЭНЭБААТАР